



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2026 оны 148 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/148 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Боловсролын салбарт хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, ачааллыг бууруулах зорилгоор ачаалал өндөртэй байршилд төлөвлөгдсөн боловсролын салбарын төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2026 оны батлагдсан төсөвт багтаан гүйцэтгэлийг эрчимжүүлж, ашиглалтад оруулж хэрэгжилт, үр дүнг 2026 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор тайлагнахыг Ажлын хэсэг /Т.Ням-Очир/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1423310111

Боловсролын сайдын 2026 оны
05 дугаар сарын 04 ны өдрийн
А/39 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Ням-Очир	Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Гишүүд:	С.Должинсүрэн	Боловсролын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга
	Ж.Дэлгэржаргал	Сангийн яамны Хөрөнгө оруулалт, хөгжлийн санхүүжилтын газрын дарга /зөвшилцсөнөөр/
	Б.Мөнхтөр	Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /зөвшилцсөнөөр/
	Б.Амартүвшин	Нийслэлийн боловсролын газрын дарга
	Г.Мөнхбаатар	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга
	Ш.Алтангэрэл	Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Х.Тамираа	Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Д.Баян-Эрдэнэ	Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга
	Э.Сүрэнхорол	Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч
	Э.Ган-Эрдэнэ	Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын ахлах шинжээч /зөвшилцсөнөөр/

	Ц.Өсөхбат	Хот байгуулалт, хотын стандартын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Л.Хангай	Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Н.Амарбаяр	Боловсролын ерөнхий газрын захиалагчийн хэлтсийн дарга

____оОо____